

## Сургууль хаагдсан тохиолдолд гэрээсээ зайнаас хичээллэх нь

### Зайнаас суралцах явцад хүүхдээ хэрхэн дэмжих талаарх зөвлөмж

#### Зайнаас суралцах үе дэх эцэг эхийн үүрэг хариуцлага

Доорх байдлаар хүүхдүүддээ дэмжлэг үзүүлээрэй.

- өдөр тутам хийх зүйлсийг хуваарилж өгч үр дүнд хүрсэн байхыг ойлгуулах
- хүүхдийн хичээллэхэд шаардлагатай орон зайг бий болгох
- багшаас нь ирж буй заавар зөвөлгөө хичээлийг хянаж байх
- өдөр бүр хичээл эхлэх, дуусахад хүүхдээсээ сурч олж мэдсэн зүйлийг нь талаар асуух
- хүүхдийнхээ суралцах явцад туслан идэвхтэй үүрэг гүйцэтгэх
- идэвхтэй дасгал хөдөлгөөн хийхийг дэмжин урамшуулах
- энэ үед хүүхдийн санаа хямарч гутралд орж магадгүйг санаж байх
- хүүхэд онлайн хэр удаан цагийг өнгөрөөж байгааг хянах
- Хүүхдийнхээ бусадтай онлайнаар холбоотой байхыг дэмжих зуур сошиал медиаг зөв зохистой хэрэглэж сургах.

#### Зайнаас суралцах явцад сурагчийн хүлээх үүрэг

Энэхүү үүргийг тухайн хүүхдийн наснаас хамааруулан өөрчлөн тохируулах ёстой:

- өдөр тутам хийвэл зохих ажлуудыг хуваарилж өгч үр дүнд хүрсэн байхыг ойлгуулах
- гэртээ хүүхдийн хичээллэхэд шаардлагатай аюулгүй, тохьтой, чимээгүй орон зайг бий болгох
- зайн сургалт явагдаж буй дижитал платформоор багшаас нь ирж буй заавар зөвөлгөө хичээлийг байнга хянаж байх
- хичээл, даалгаврыг үнэн шударгаар өөрийн хүч чадлаа дайчлан гүйцэтгэх
- хичээл, даалгавар, хүлээн авсан аливаа ажлыг хугацаанд нь хийж дуусгахын тулд өөрийн хүч чадлаа дайчлах
- хэрэв даалгаврыг хугацаанд нь дуусгах чадахгүй, эсвэл нэмэлт дэмжлэг хэрэгтэй байгаа бол багштайгаа холбогдох, нэмэлт дэмжлэг хүсэх
- суралцах явцдаа бусад сурагчидтай хамтран бие биенээ дэмжиж ажиллах
- Боловсролын яамны [Student use of digital devices and online services policy](#) журмыг мөрдөх
- Хэрэв аливаа өөр хэрэгцээ шаардлага үүсвэл сургуулийн багш, албан хаагчидтай холбогдож мэдэгдэх.

## Хүүхдийнхээ өдрийг төлөвлөх

Сургууль нь сурагчийн хичээл хийх хуваарийг гарган танд өгөх ёстой. Энэ хуваарьт таны хүүхэд хэзээ завсарлага авах, цайны цаг хэзээ байх ёстойг тусгасан байх болно. Завсарлагын үед хүүхэд босч биеийн идэвхтэй дасгал хөдөлгөөн хийх нь чухал.

Хэрэв та хувийн байранд амьдардаг бол хүүхэд байшингийнхаа балкон, эсвэл арын цэцэрлэгт гарах нь аюулгүй.

## Хүүхдийн эрүүл мэнд

Гэртээ удаан хугацаагаар гарахгүй байх нь таны хүүхдийн сэтгэл санаанд сөргөөр нөлөөлж болзошгүй юм. Ийм нөхцөл байдалд та доорх байдлаар хүүхэддээ туслах хэрэгтэй:

- гэр бүлийн бүх гишүүдтэйгээ халдварт тархалтын талаар ярилцан байдлыг ойлгуулах нь сэтгэл санаанд сөргөөр нөлөөлөхөөс сэргийлнэ
- урд өмнө нь тохиолдож байсан хүнд нөхцөл байдлыг хэрхэн даван туулж байсан талаар хүүхэддээ бодоход нь тусалж энэ удаад ч үүнийг чи даван туулж чадна гэдэгт итгүүлээрэй
- тусгаарлалтанд байх нь удаан үргэлжлэхгүй гэдгийг сануулж байх
- биеийн тамир дасгал хөдөлгөөн байнга хийлгүүлэх – энэ нь хүүхдийг сэтгэлийн хямрал, гутралд оруулахаас сэргийлнэ
- Хүүхэд өөрийн найз нөхөд, гэр бүлийн гишүүд, хамаатан садантайгаа утсаар, е-мэйлээр, (хэрэгтэй бол) сошиал медиагаар дамжуулан холбоотой байхыг нь дэмжих.

## Харилцаа холбоо

### Хүүхэдтэйгээ харилцах

Хүүхэд тань тухайн өдөрт гүйцэтгэх хичээлээ төлөвлөхөд нь туслах зорилгоор та өдөр бүрийг эхэн болон төгсгөлд хэдэн энгийн асуултуудыг асууж байгаарай гэж зөвлөж байна. Бүх сурагчид зайнаас суралцах явцыг амжилттай даван туулдаггүй, зарим нь хэт их бие даасан байдалд дасдаггүй, зарим нь хичээлээ төлөвлөгөөний дагуу хийж чаддаггүй гэх мэт асуудал гардаг тул таны асуух асуултууд хүүхэд тань хэвийн суралцахад нь туслах болно.

### Сургуультай харьцах

Сургууль болон багш нар тантай ямар сувгаар тантай харилцахыг та мэдэж байх ёстой бөгөөд эдгээр мэдээллийн харилцах сувгуудыг та байнга шалгаж байх ёстой.

Хүүхдээ сургахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор багш нараас нь хэрхэн дэмжлэг авахаар холбогдож болох вэ гэдгийг та мэдэж байх ёстой. Мөн сургуулиас дижитал хэрэгсэл сургалтын зорилгоор өгсөн бол та техникийн талаарх тусламжийг хэнээс авах ёстой вэ гэдгээ мэдэж байх ёстой.

Ихэнх гэр бүл болон сургуулиудад зайны сургалт нь шинэлэг зүйл юм. Сургуулиуд эцэг эх сурагчдаас санал бодлыг нь хүлээн авч сургалт, холбоогоо сайжруулах байнгын шаардлага гарч байгаа тул танаас болон таны хүүхдээс систем хэрхэн ажиллаж байгаа талаар саналыг тань асуух болно.

Ихэнх сургуулиуд эцэг эхчүүд болон сурагчтай харьцах дижитал платформыг бий болгон хэрэглэж байгаа. Боломжтой бол энэхүү сувгийг ашиглан харилцаж байх хэрэгтэй.

### Багш нартай харилцах нь

Багш нар өөрсдын сурагчидтай онлайнаар харилцан ярилцах, видео хичээл заах цагийг хуваарилан товлосон байж болно. Дижитал аргуудыг хэрэглэх боломжгүй болсон бол багш нь сурагчтай утсаар цаг товлон ярилцаж болно.

Та болон таны хүүхдийн санавал зохих нэг зүйл бол багш нар олон бусад гэр бүлтэй харьцах ёстой байдаг учир та багш нартай харилцах богино хугацааг сайтар ашиглаарай. Мөн багш таны хүүхэдтэй эргэн холбогдтол хүлээх шаардлага гарсан үед хүүхэддээ тэвчээрэй хандахыг сануулаарай.

## Технологийг ашиглах нь

Энэхүү шинэ нөхцөл байдал гарсантай холбогдуулан, сургуулиас танд зөвлөөгүй л бол, та аливаа гуравдагч этгээдээс програм худалдан авахгүй байхыг чухалчлан зөвлөж байна.

Боловсролын яам болон сургууль төрөл бүрийн програм болон төхөөрөмжүүдтэй бөгөөд таны хүүхдийн сурах шаардлагад тохирсон төхөөрөмжийг сонгосон байгаа болно.

- Google Apps for Education – Online Google apps. Сурагч доорх замаар нэвтэрнэ: Students portal > Learning > G Suite.
- Office 365 – online Office apps.
- Microsoft Office 365 Desktop Apps –ийг 5 компьютер болон 10 хүртэлх тооны хөдөлгөөнт төхөөрөмжид суулгаж болно. 'Install Office' гэсэн холбоосыг сонгоорой.
- Сурагч нэмэлтээр үнэ төлбөргүй байдаг Adobe программыг өөрийн төхөөрөмжинд суулгаж болох бөгөөд ингэхийн тулд сурагчдын Bring your own device (BYOD) програм хангамжын веб хуудас руу ороорой.

## Дижитал хэрэгсэл болон интернэтэд холбогдох нь

Боловсролын яамнаас гаргасан технологи, тоног төхөөрөмж, интернет ашиглах журамтай дараах холбоосоор орон танилцана уу.

[Student use of digital devices and online services policy](#) (Сурагчийн дижитал хэрэгсэл болон онлайн үйлчилгээр ашиглах журам)

Хэрэв сурагчид сургуулиас сурах даалгаврыг дижитал хэлбэрээр өгсөн бөгөөд сурагч нь хэрхэн үүнийг хийх талаар мэдэхгүй байгаа бол тухайн багштай холбогдон дэмжлэг аваарай.

## Дэлгэцэн дээр өнгөрөөх цагийн менежмент

Сурагчийн онлайн өнгөрөөх цаг хязгаартай байх ёстой ч, сурагчийн наснаас хамаарч онлайн байх цаг болон ашиглах дүрэм өөр өөр байна.

Видео конференц хийх, видео ашиглан сошиалаар харилцах цагийг дэлгэцэнд өнгөрөөсөн цагт тооцдоггүй.

Америкийн хүүхдийн эмгэг зүй судлалын академээс гаргасан зөвлөмжөөр доорх дэлгэцийн цагийг (видео конференц хийх цагийг оролцуулахгүйгээр) хүүхдэд тохиромжтой гэж үзэж байна:

- 2-5 насныхан: 1 цаг, хамгийн ихдээ 30 минут байхаар бодож дунд нь завсарлагатайгаар
- 6 болон түүнээс дээш насныхан: дэлгэцэн дээр өнгөрөөх цагийн тодорхой хязгаар байхгүй ч энэхүү цаг нь хөдөлгөөнийг гэртээ болон сургууль дээр тухайн сурагчийн хүн-хүнтэй харьцах болон биеийн идэвхтэй дасгал хөдөлгөөний цагийг хязгаарлахаар байж болохгүй (аль болох). Дэлгэцэн дээрх цагийн хязгаарлалтыг үргэлж мөрдүүлж хэвшүүлэх нь маш чухал юм.

Сургуулиас гадуурх аливаа хичээл дугуйланд хамрагдах цагийг хязгаарлах.

## Зан байдлын менежмент

Хүүхэд тань хэдийгээр гэртээ байгаа ч гэсэн сургуулийн зан байдлын талаарх журмыг баримтлах ёстой.

Зайнаас суралцах явцад бусадтай хамтран хичээллэх, баг болж ажиллах, үе тэнгийхэнтэйгээ санал бодлоо хуваалцах зэрэг нь тухайн сурагчийг онлайн аар дижитал орон зайд бусадтай хамтран ажиллахыг шаардана. Энэ үед сурагчийн биеэ авч явах байдал нь сургууль дээр хичээлийн танхимд нүүр тулан ажиллах үед тавигддаг шаардлагатай ижилхэн байна.

## Утсан орчуулгын үйлчилгээ

Хэрэв танд нэмэлт мэдээлэл хэрэгтэй бол сургуулийн захиралтай холбогдоорой. Хэрэв танд орчуулагч хэрэгтэй бол Утсан Орчуулгын Үйлчилгээний төвтэй 131 450 дугаараар холбогдон өөрийн хэл дээр орчуулгын үйлчилгээ авч болно. Энэ үйлчилгээ нь үнэ төлбөргүй болно.